



## ЭРЭНДООГИЙН ЛУВСАННАВААН

Улаанбаатар хотын захиргааны дарга  
1941.09-1941.11

Хуучнаар Сэцэнхан аймаг Өндөрхаан уулын хошуу одоогийн Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт 1908 онд төрсөн. Багадаа гэрийн багшаар бичиг заалгаж суралцсан.

1928 оноос баг, хорины дарга, 1930-1935 онд Цэрэгт бага, дунд тушаалын дарга, аймгийн цэргийн хэлтсийн дарга, Монгол банкинд байцаагч, даргын дагалдан, хэлтсийн эрхлэгч, аймгийн анхны хэлтсийн даргаар ажиллаж байгаад 1939-1940 онд Улаанбаатар хотын намын хорооны орлогч дарга, 1940-1941 онд Хөвсгөл аймгийн захиргааны дарга,

1941 оны есдүгээр сараас 11 дүгээр сар хүртэл Улаанбаатар хотын захиргааны даргаар хоёр сарын хугацаанд ажиллажээ.

Э.Лувсаннаваан нь МАХН-ын X, БНМАУ-ын VIII хуралд төлөөлөгчөөр

оролцож, Намын төв хорооны гишүүнээр сонгогдож байсан юм. МАХН-ын Төв хорооноос намын байгууллага, гишүүдэд лам нарын асуудал, хүрээ хийдийн талаар илгээсэн “нууц” захидалтай танилцаад "Доод лам нар" гэгчийг жирийн ардын адил үзэж байх тухай МАХН-ын Төв Хороонд 1938 онд зөв зүйтэй асуудал оруулж бичсэн нь хариултын хамт хэвлэлд нийтлэгдэж байжээ.

1942 онд хилс хэрэгт баривчлагдсан бөгөөд АИХ-ын тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах комиссын 1958 оны тавдугаар сарын 13-ны өдрийн 30 дугаар тогтоолоор уг хэрэгт холбогдолгүй учир цагаатгагджээ.

